

Үндэсний онцлогтой үг хэллэгийн орчуулгын асуудалд

Г.Сайнбаяр /МУИС, ГХСС/

Товч агуулга: *Үндэсний онцлогтой үг хэллэгийг орчуулна гэдэг амаргүй ажил бөгөөд эх зохиол дээр гарч буй үг, хэллэг тухайн улсынхаа соёлтойгоо гүн холбоотой байх тусам орчуулахад бэрх байдаг. Тиймээс үндэсний онцлогтой үг хэллэгийг орчуулгын хэлэнд эх хэл дээрхийн адил утга төгөлдөр орчуулах боломжгүй гэж зарим эрдэмтэд үзэж байхад эх хэл дээрх зохиолын зорилгоос хамаарч орчуулгын олон аргыг ашиглан хамгийн ойр дөт дүйцүүлэн, тэнцвэрт байдлыг хадгалж орчуулж болно гэж зарим нь үздэг. Энэхүү өгүүлэлд монгол болон англи орчуулагч монголын нэгэн богино өгүүллэгийг англи хэлэнд орчуулахдаа орчуулгын олон аргыг хэрэглэн үндэсний онцлогтой үг хэллэгийг хэрхэн орчуулсаныг жишээн дээр тайлбарлан мөн эх зохиолыг орчуулахдаа хоёр орчуулагч орчуулгын тэнцвэрт байдлыг хэрхэн хадгалсаныг харуулахыг зорилоо.*

Түлхүүр үгс: *соёл, соёлын орчуулга, орчуулгын арга, үндэсний онцлогтой үг хэллэгийн дүйцэл, орчуулгын тэнцвэрт байдал, эх хэл, орчуулгын хэл*

I. Оршил

Соёлын орчуулгын талаарх анхны онолыг 1963 онд Францын эрдэмтэн Жорж Моунин дэвшүүлсэн бөгөөд хамгийн сайн орчуулга гэдэг нь соёлын холбоотой зүйлийг үнэн зөв орчуулах ингэснээр тухайн орчуулга зорилгоо бүрэн биелүүлж байгаа юм гэж үзсэн байдаг.

Соёлын орчуулга судлалын анхны ойлголтыг 1978 онд Изралийн эрдэмтэн Евен-Зохар Полисистем, орчуулгын хэм хэмжээ гэсэн бүтээлдээ, 1980 онд Изралийн эрдэмтэн Гидеон Тоури өөрийн бүтээлдээ Соёлын эргэлт (Cultural turn) гэж үзсэн байдаг. Эдгээр эрдэмтэд орчуулгыг хэл шинжлэлийн үүднээс авч үздэг онолуудаас татгалзаж, орчуулга болон соёлын хоорондын харилцан нөлөөлөлд анхаарлаа хандуулж, эх бичгийн орчуулгаас соёлын орчуулга руу шилжсэн шилжилтийг Соёлын эргэлт гэж үзжээ.

2004 онд Голландын судлаач Нико Виерсема “Даяаршил ба орчуулга” өгүүлэлдээ англи хэл дэлхийн харилцааны гол хэл бөгөөд даяаршил орчуулга судлалтай холбоотой гээд үндэсний онцлогтой үг, хэллэгийг хүнийшүүлэх (ондоошуулах “foreignizing”) хэлбэрээр бичих, ингэснээр гадны соёлыг ойлгохдоо тэр орчуулга дээр гарсан үг хэллэгийг толь бичиг, интернетээс хайж олж судалж болно гэсэн санаа дэвшүүлсэн ба түүнийхээр үндэсний онцлогтой үг, хэллэгийг орчуулах 3 арга байна гэжээ. Үүнд: 1. Гадаад үг хэллэгийг аливаа тайлбаргүйгээр хэрэглэх; 2. Гадаад үг хэллэгийг дэлгэрэнгүй тайлбартайгаар хэрэглэх; 3. Орчуулгын хэлний уншигчдад илүү ойлгомжтой болгох үүднээс эх зохиолыг дахин бичих.

Орчуулга нь хоёр хэл, соёлыг зайлшгүй хамаардаг үйл явц учир орчуулагч эх хэл дээрх үндэсний онцлогтой үг хэллэгийг орчуулгын хэлэнд хамгийн ойр дөт дүйцүүлэн орчуулах асуудалтай байнга тулгардаг. Гэхдээ орчуулгад тулгардаг тухайн асуудал нь хоёр хэлний соёл болон хэл шинжлэлийн ялгаанаас ихээхэн хамаардаг. Аливаа орчуулгыг хийхэд хоёр хэлний соёлын ялгаа хэлний бүтцийн ялгаанаас илүү төвөгтэй байдаг. Өөрөөр хэлбэл хоёр хэлний соёлын ялгаа хэдий их байна тэр хэрээр орчуулгын ажил хүнд байна гэсэн үг. Тиймээс хэл, соёлын асуудлыг анхаарч, үндэсний онцлогтой үг хэллэгийг орчуулахдаа шууд дамжуулах, харьцуулан дүн шинжилгээ хийх гэсэн хоёр өөр аргыг хэрэглэж болохыг АНУ-ын эрдэмтэн Петер Ньюмарк дэвшүүлсэн. Түүний дэвшүүлсэн шууд дамжуулах арга нь үндэсний онцлогтой үг хэллэг, агуулгыг хэвээр хадгалж “нутгийн өнгө”-ийг гаргах явдал юм. Энэхүү арга нь соёлын тухай ойлголтод хэдийгээр ач холбогдол өгч буй боловч ерөнхийдөө соёлын холбоотой нарийн тодорхой ухагдахууныг бүрэн илэрхийлэх боломжийг хязгаарлаж буй юм. Хариин харьцуулан дүн шинжилгээ хийх арга нь орчуулгын тэнцвэрт байдлыг хадгалж, үгийн утганд өндөр ач холбогдол өгдөг гэж тэрээр үзсэн байна. Соёлын ялгааг харгалзан орчуулга хийх аргуудыг дэвшүүлсэн байдаг. Үүнд:

1. Зээлдэн авах арга
2. Хоёр, эсвэл гурав, дөрвөн аргыг хослуулан хэрэглэх
3. Дүрслэх, гүйцэтгэх үүргээр нь тэнцвэрт байдлыг хадгалж орчуулах
4. Зүүлт хийж тайлбарлан орчуулах арга
5. Дүйцэх үгээр орлуулан орчуулах арга
6. Нөхөх арга

Үндэсний онцлогтой үг хэллэгийг эрдэмтэн Петер Ньюмарк дараах байдлаар ангилсан байна. Үүнд:

1. Экологи: ургамал, ан амьтан, уул толгод, салхи шуурга, тал хөндий
2. Материаллаг соёл: хувцас, хоол хүнс, байр сууц, хот тосгон, тээвэр
3. Нийгмийн соёл: ажил, чөлөөт цаг
4. Зохион байгуулалт: ёс заншил, баяр ёслол, ёс журам
5. Дохио зангаа, уламжлалт ёс заншил

Е.Баярсайхан, Р.Гүрбазар, А.Шархүү зэрэг эрдэмтэн судлаачид үндэсний онцлогтой үгийг ангилж, орчуулгын аргуудыг дурьдсан байдаг. Жишээ нь: А.Шархүү үндэсний онцлогтой үгийг 5 зүйлд ангилжээ. Үүнд:

1. Нийгэм, улс төрийн үйл амьдралтай холбоотой үг
2. Тухайн улс, үндэстний амьдралын хэв шинж, эрхлэх аж ахуй, үйлдвэрлэлийн онцлогийг илтгэх үг
3. Амьдрал ахуйд уламжлагдан үлдсэн ахуйн болон оюуны хүрээний эд өлгийн зүйлийн нэр
4. Уламжлалт ба шинэ тутам бий болсон зан үйл, ёс заншилд холбогдох үг хэллэг
5. Түүхэн үг

Е.Баярсайхан үндэсний онцлогтой үгийг орчуулах аргыг галигаар буулгах, хуулбарлаж шинэ үг бүтээх, утга ойролцоо үгээр орлуулах, тайлбарлан орчуулах, өөр хэлэнд байгаа дүйх үгээр орчуулах, орчуулгад зүүлт тайлбар хийх тэрчлэн галигаар буулгах тайлбарлан орчуулах хоёрыг хослуулан хэрэглэх зэрэг хэд хэдэн арга байна гэжээ. Харин А.Шархүү үндэсний онцлогтой үгийг нэг хэлнээс нөгөө хэлэнд дамжуулах талаар 4 зүйл арга, боломж бий гээд дор дурьдсанаар ангилсан байдаг. Үүнд:

1. Утга ойролцоо үг хэллэгээр нөхөн орчуулах
2. Уг үндэсний онцлогтой үгийн илэрхийлж байгаа утга санаа, дүр төсөөллийг өөр үг хэллэгээр тайлбарлан буулгах
3. Хуулбарлан орчуулах
4. Үндэсний онцлогтой үгийг галиглан буулгах аргууд орж байна.

Эх зохиолыг орчуулахдаа дээрх орчуулгын аргуудыг хэрхэн хэрэглэсэн байна гэдгийг авч үзье.

II. Үндэсний онцлогтой үг хэллэгийн орчуулга, орчуулгын арга

Их зохиолч Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” өгүүллэгийг Английн Монголч эрдэмтэн Чарлиз Боуден, Монголын орчуулагч Д.Лхамжав нар англи хэлнээ орчуулжээ.

Зохиолч Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” өгүүллэгт олон үндэсний онцлогтой үг, хэллэг орсон байдаг. Эдгээр үгсийг жагсааж харуулбал:

Үндэсний онцлогтой үг, хэллэг	Д.Лхамжавын орчуулга	Ч.Боудены орчуулга
Ламбугайн нулимс	Tears of Venerable Lama	The Tears of the Reverend Lama
Гэвш	Father	Bachelor of Divinity
хүрдийг бясалгах	-	venerated his prayer-wheel
винайн ёс	Vinaya (Clerical discipline, one of the Tripitaka)	Laws of the Discipline
Гандан	Gandan	Gandang lamasery
баруун дамнуурчны гудамж	Chinese Hawkers	Chinese Western Pedlars quarter
хувраг	wealthy monk	high cleric
янчаан	some tugrug	bit of spending money
Зүүн хүрээ	East Monastery	Eastern Lamasery
Орхимж	orkimzi	scarf
дээл хувцас	clothes	clothes
муутуу	Chinese paper	Chinese paper
Цагаан дарь эх	White Tara	Goddess Dar Ekh
гүнгэрваатай бурхан	small framed icons of	Buddha-statue in a frame

	Buddhas	
Дуйнхарын аймаг	Duinkher	Duinkhar Quarter
дөрвөн ханатай гэр	four-walled gerr	four-section tent
баруун зуу	Western Zuu	Lhasa
гавж	Gabji-degree of doctor of Buddhist philosophy	degree of Doctor
хорооны газар	-	secular district
хуврагийн ёс	holy priesthood vows	religious vows

Хоёр орчуулагчийн хэрэглэсэн аргуудыг жишээгээр харуулбал:

1. **Утга ойролцоо үгээр орчуулсан нь:**

“Орчлон ертөнцийг хоосон гэж **хүрдийг** бясалгаж ...” гэснийг Чарлиз Боуден “As the Bachelor of Divinity Lodon, who venerated his **prayer-wheel**...” гэж орчуулжээ. “Гэвш Лодон ам хамрыг **орхимжоороо** бөглөн, хүүхний хойноос намс намс алхлана.” гэснийг Чарлиз Боуден “The Bachelor of Divinity Lodon covered his nose with his **scarf**” гэжээ.

2. **Галигаар бүүлгасан нь:**

“Орчлон ертөнцийг хоосон гэж **хүрдийг** бясалгаж, винайн ёсыг сахисан гэвш Лодон улаан шарыг тунуулсаар, **гандангийн** наад хүр рүү бууж ирмэгц...” гэснийг Чарлиз Боуден “...was coming down the gully on this side of the **Gandang lamasery**...”, Д.Лхамжав “...went down the eastern terrace of **Gandan**...”, “Орчлон ертөнцийг хоосон гэж **хүрдийг** бясалгаж, **винайн ёсыг** сахисан гэвш Лодон”-ыг Д.Лхамжав “When Father Lama Lodon, a master of the **Vinaya**”, “Гэвш Лодон ам хамрыг **орхимжоороо** бөглөн, хүүхний хойноос намс намс алхлана.” гэснийг Д.Лхамжав “Father Lama Lodon walked smartly after the girl covering his mouth and nose with one end of his **orkimzi**” гэсэн байна.

3. **Тайлбарлан орчуулсан нь:**

“Орчлон ертөнцийг хоосон гэж **хүрдийг** бясалгаж, **винайн ёсыг** сахисан гэвш Лодон”-ыг Чарлиз Боуден “As the **Bachelor of Divinity** Lodon, who venerated his prayer-wheel and obeyed the **Laws of the Discipline**”, “**баруун дамнуурчны шавартай гудамж**” гэснийг цаад утгыг нь бүрэн гүйцэт гаргахын тулд Чарлиз Боуден “**Chinese Western Pedlars quarter**”, Д.Лхамжав “**Western muddy street of Chinese Hawkers**” гэж тайлбарлан орчуулжээ. “Нэг бага цонхыг хоёр давхар **муутуугаар** битүүлэн нааж, улаан цаасаар угалзлан чимжээ.” Чарлиз Боуден “A little window was pasted over with two layers of **Chinese paper** and decorated with patterns in red paper.”, Д.Лхамжав мөн адил “A small window was sealed with two layers of soft **Chinese paper** decorated with spiral patterns cut out of red paper.” гэж орчуулжээ.

4. **Өөрийн хэлэнд байгаа дүйх үгээр орчуулсан нь:**

“Иүй Май-хуйгийн хар тамхи тасарсан учир, нэг алтан бөлзөгийг бариулж, хэдэн **янчаан** олж хэрэглэхийг зорьж явсан нь...” гэснийг Чарлиз Боуден “Yu Baihua had run out of opium and was on her way to pawn a gold ring and get a bit of spending **money**”, “...Иүй Бай-хуад гуа сайхан элбэг дэлбэг хашаа байшин төхөөрч **хорооны газар**

хамтран суух болов.”-ийг Чарлиз Боуден “...fitted out a luxurious compound and house for Yu Baihua, and they began to live together in the **secular district**.”, “Цонхны булангын завсраар нууж үзвэл, Иүй Бай-хуа нэг залуу **хар хүүтэй** тэврэлдэн сууна.” Чарлиз Боуден “When he looked furtively in through a gap in the window, there was Yu Baihua in the embrace of a young **layman**.” хэмээн зөв буулгажээ.

5. **Зүүлт тайлбар хийж орчуулсан нь:**

Орчуулагч Д.Лхамжав зарим нэг үндэсний онцлогтой үгийг галиглан бичээд доор нь зүүлт хийж тайлбарласан байна. Үүнийг хүснэгтээр үзүүлвэл:

Винай	Vinaya	Clerical discipline, one of the Tripitaka
янчаан	tugrug	Mongolian monetary unit, 4 tugrugs equal to US dollar.
орхимж	orkimzi	Orkimzi-scarf usually red, consisting of a wide and long piece of cloth which lamas wrap around the body, throwing the end over the left shoulder
Цагаан Дар эх	White Tara	The most popular goddess of Mahayana Buddhism
Дуйнхар	Duinkher	An old district in Urge where lamas lived
Баруун зуу	Western Zuu	Lhasa, the capital of Tibet

Хамгийн их сонирхол татсан зүйл нь Гэвш Лодон улаан шар нөмрөг өмссөн Цэрэнлхам цагаан харыг гялалзуулсан хувцастай гэж Д.Лхамжав орчуулжээ. Чарлиз Боуден Лодонгийн нөмрөг улаан шар хосолсон, Цэрэнлхамын хувцас биш нүд нь хар цагаанаар гялалзаж байгаа мэтээр орчуулсан нь нэн сонирхолтой байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Чарлиз Боудэний орчуулга

Д.Лхамжавын орчуулга

As the Bachelor of Divinity Lodon, who venerated his prayer-wheel and obeyed the Laws of the Discipline, because he saw the turning world as vain, was coming down the gully on this side of the Gandang lamasery, his robes mingling their red and yellow, the girl Tserenkhlan, also known as Yu Baihua, who had mastered the skill of fostering the sharp sword of passion, emerged from a muddy lane in the Chinese Western Pedlars quarter, **flashing her eyes, black against white**, and they met.

When Father Lama Lodon, a master of the Vinaya who was wearing a yellow gown and a red robe, and was meditating on the fact that the world was empty, went down the eastern terrace of Gandan, he came across miss Tserenlhama, an experienced girl skilled in the heat of passion, who was **wearing shining white and black** and who had just come out of the Western muddy street of Chinese Hawkers.

Д.Отгонсүрэн “Д.Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог, Ламбагуайн нулимс өгүүллэгийн дүр, хэлний шүтэлцээ” бүтээлдээ дээр өгүүлж буй эмэгтэй дүрийн нүд бус өмссөн хувцас нь цагаан харыг гялбуулсан болох нь үнэн гэж тайлбарлан бичсэн байдаг. Орчуулагч Д.Лхамжав Цэрэнлхам хүүхний хятад нэрийг огт дурьдалгүй өнгөрчээ.

Дүгнэлт

Англи хүн энэхүү орчуулахад адармаатай үндэсний онцлогтой үг, хэллэгийг орчуулна гэдэг амаргүй. Монгол хэлийг нэлээд гаргуун эзэмшсэн гэдэг нь түүний орчуулгаас харагдаж байна.

Ч.Боуден эх зохиолын өгүүлбэрийг олон жижиг өгүүлбэр болгон орчуулаагүй, үг орхиогүй боловч ташаа ойлгож орчуулсан, энэ өгүүллэгт ямар нэгэн зүүлт тайлбар хийгээгүй байх ба зарим нэг үгийг өөрийн зохиосон “Mongolian-English Dictionary” толь бичигт байх үгнээс тэс өөр үгээр орчуулсан байх ба барууны уншигчдад зориулж орчуулсан нь үүнээс харагдаж байна.

Д.Лхамжав үндэсний онцлогтой үгсийг галиглан буулгаад зүүлт хийж тайлбарлах аргыг түлхүү хэрэглэж, зарим үгийг орхиж /хүүхний нэр, хүрд, шээх г.м/, олон жижиг өгүүлбэр болгон салгаж орчуулсан байна.

Эх зохиолын нэг өгүүлбэр дээр гарч буй үндэсний үг хэллэгийг орчуулахдаа хоёр орчуулагч өөр өөр орчуулгын аргыг, зарим тохиолдолд ижил аргыг хэрэглэсэн байна.

Эцэст нь дүгнэн хэлэхэд орчуулгын онолд “Бүхий л хэв шинжийн болоод зүйл зүйлийн сэдвийг хөрвүүлэх алив тохиолд орчуулагчийн эрхэмлэвэл зохих зүйл нь тэнцүү чанарт орчуулга” гэж үздэг бөгөөд хоёр орчуулгын хувьд бүхэлд нь авч үзвэл орчуулгын олон аргыг хэрэглэн орчуулгын тэнцвэрт байдлыг хадгалж хийсэн байна гэж үзэж болохоор байна.

Abstract

The two translations both meet the equivalent. However, there are many differences in some of names of places, roles and degrees in the two versions. Such as the Mongolian translator did not mention the Chinese name of Tserenlkham whereas the English Mongolist misunderstood that the female role was flashing her eyes, black against white. In fact the lady was wearing shining white and black. The Mongolian translator transliterated real words and words related to religion and gave their explanations and notes in the footnote. Finally, the version of Charles Bawden seems to be dedicated to Western readers. The reason is that he did not use the words he compiled in his “Mongolian-English Dictionary” published in 1997.

Ном зүй

1. Г.Аким, “Орчуулгын санг уудлахад”, Улаанбаатар, 1984.
2. Р.Гүрбазар, “Орчуулгын онол, дадлагын үндэс”. Улаанбаатар, 1996.
3. Д.Дашдаваа, “Орчуулгын зарим асуудал”, Улаанбаатар, 1977.
4. Д.Дашдаваа, “Уран зохиолын орчуулгын тухай”, Улаанбаатар, 1988.
5. Монголын орчин үеийн утга зохиолын түүх, I-р боть, Улаанбаатар, 1985.
6. МУИС, Монгол судлалын төв, “Монгол хэлний хэл зүйн толь бичиг”, Улаанбаатар, 2005.

7. Орчуулах эрдэм, Улаанбаатар, 1982.
8. Орчуулах эрдэм, Улаанбаатар, 1976.
9. Орчуулах эрдэм, Улаанбаатар, 1988.
10. Д.Отгонсүрэн “Д.Нацагдоржийн зохиолын хэл найруулга, уран сайхны онцлог”, Улаанбаатар, 1984.
11. О.Сүхбаатар, “Монгол хэлний харь үгийн толь” (Нэмж засварласан 2 дугаар хэвлэл, Улаанбаатар, 1999.
12. Я.Цэвэл, “Монгол хэлний товч тайлбар толь”, Улаанбаатар, 1963.
13. А.Шархүү, “Үндэсний соёлын ялгаа ба орчуулгын зарим асуудал”, Улаанбаатар.
14. Sugeng Hariyanto. The Implication of Culture on Translation Theory and Practice. Translation Journal.
15. Zahra Davoodi (September 2009). On the Translation of the Taboos. Translation Journal.
16. Javad Heidary (2009). Cultural Equivalence and Linguistic Equivalence. Translation Journal.
17. Kanji Kitamura (July 2003). Cultural Untranslatability. Volume 13, No.3, Translation Journal.
18. Mahmoud Ordudari (July 2007). Translation procedures, strategies and methods. Translation Journal, Volume 11, No.3.
19. Peeter Torop (2002). Translation as translating as culture. Sign Systems Studies 30.2.
20. Mohammed Albakry (October 2013). Linguistic and cultural issues in literary translation. Volume 17 No., Translation Journal.
21. Samira Mizani (October 2013). Cultural Translation. Volume 17, No.4, Translation Journal.
22. Newmark, Peter (1981). Approaches to Translation. Oxford: Pegamon Press.
23. Kate James (2002). Cultural Implications for Translation. Translation Journal.
24. Mohammed Albakry (October 2013). Linguistic and cultural issues in literary translation. Volume 17, No.4, Translation Journal.